

ЦЭНХЭРМАНДАЛЫН БИЧЭЭС

Ц.БАТТУЛГА, Н.ГЭРЭЛМАА

МУИС-ийн Гадаад Хэл Соёлын Сургууль, Түрэг Судлалын Төв,
e-mail: ts_battulga@yahoo.com; gerel00976@yahoo.com

Түлхүүр үгс: Руни бичиг, Бургастайн бичигт цохио, Цэнхэрмандал

Өгүүллийн товч агуулга: Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутагт “Бургастайн бичигт цохио” хэмээх газар буй хоёр мөр руни бичгийн дурсгалыг эрдэмтэд “Цэнхэрмандалын бичээс”, “Хэнтийн бичээс” гэж өөрөөр нэрлэн судалгааны эргэлтэд оруулсан байдаг. Бичээсийг уншиж судалсан эрдэмтдийн санал нэг мөр болоогүй учир эл бичээсийг бид өөрсдийн хувилбараар уншиж тайлсан судалгаагаа толилуулж байна.

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумаас холгүй, “Бургастайн бичигт цохио” хэмээх газар хоёр мөр руни бичгийн дурсгал буй бөгөөд манай судалгааны ном зохиолд “Цэнхэрмандалын бичээс”, оросын болон туркийн эрдэмтэд “Хэнтийн бичээс” хэмээн өөр өөрөөр нэрлэжээ.

Д.А.Клеменц Дорнод Монголоор аялахдаа 1895 оны 5-р сард энэ бичээсийг анх олсон тухай доктор Л.Болд бүтээлдээ тодорхой өгүүлсэн байдаг (Болд, 1990: 139-142).

Уул мэдээллийн мөрөөр С.Е.Киселевийн удирдсан шинжилгээний анги 1949 онд үзэж нягтлан гэрэл зураг, гар хуулбар авчээ*.

Угсаатны зүйч К.В.Вяткина 1958 онд эл бичээсийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор мэдээлсэн байна (Вяткина, 1958: 217-218).

К.В.Вяткина гуайгаас авсан гэрэл зурагтаа дулдуйдаж Фэн Цзя-шэн эл хоёр мөр бичээсийг уншиж тайлсан судалгаагаа 1959 онд хэвлүүлжээ (Фэн Цзя-шэн, 1959: 3-6).

Б.Ринчен академич 1968 онд (Rintchen, 1968: 43), нэрт түүхч Х.Пэрлээ академич 1974 онд (Пэрлээ, 1968: 12; 1974: 71-74) Цэнхэрмандалын бичээсийн гэрэл зураг болон гар хуулбарыг нийтлүүлжээ. Б.Ринчен академич “Үнэн” сонинд ажиллаж байхдаа “Новости Монголии” сонинд уг бичээсийн тухай мэдээлэл нийтлүүлсэн гэдэг.

Дорнод Монголоос нилээд эрт үед олдсон энэ бичээсийг 1975 оны зун Монгол-Зөвлөлтийн хээрийн шинжилгээний анги үзэж дахин нягтлан судалсан тайлсан судалгааны дүнгээ хэвлэн нийтлүүлсэн ажээ.

*Энэ хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд нэрт эрдэмтэн С.Е.Киселев, К.В.Вяткина болон МУИС-ийн оюутан Х.Лувсанбалдан (хожмын тод үсэг бичиг судлаач, нэрт эрдэмтэн), И.Шарав-Иш нар оролцсон гэдэг.

Фэн Цзя-шэний судалгаа, орчуулгын талаар М.Шинэхүү абугай “Цэнхэрмандалын эртний түрэг бичээсийг дахин уншсан нь” хэмээх өгүүлэлдээ тухайлан өгүүлсэн байдаг билээ.

Цэнхэрмандалын руни бичээсийг уншиж орчуулсан эрдэмтдийн судалгааг тоймлон дурдвал:

Фэн Цзя-шэний судалгаа

Үсгийн галиг: sč: öz: tng: üyir: qg: b: küsnč-ü: yil: qa (i): qon: tb

Үгийн галиг: Sačī: öz: tang: üyir: qugu: äb: küsänč-ü: yil: qa (i): qon: t äbä

Орчуулга: Сачи сам утром услышал лебедя, желаящего (найти) гнездо, желают (чтобы были) бык, конь, баран, верблюды (Фэн Цзя-шэн, 1959: 3-6).

М.Шинэхүү гуай Фэн Цзя-шэний орчуулгыг монгол хэлнээ “Сачи өөрөө үүрээ (олохыг) хүссэн хунгийн дууг өглөөгүүр сонссон, үхэр (шар), морь, хонь, тэмээ (-тэй болохыг) (хүсэцгээжээ) хэмээн буулгасан байна (Шинэхүү, 1977:102).

Фэн Цзя-шэн эл бичээсийг уйгурын үед холбогдоно гэж үзсэн ажээ.

М.Шинэхүү гуайн судалгаа

Бичээсний галиг нь:

1. i č i ö z n nč ü: q i r Г m
2. k ü s g ü j i q a : q o n t m

Бичээсийг тоймлон уншвал:

1. i č i ö z inänčü qirГim
2. küsgü jilqa: qonatim гээд хоёр хувилбараар орчуулсан байна.

Нэгдүгээр хувилбар:

1. Ичи (шадар) өж (нөр) үнэнч би устгав.
2. (Тэгээд) хулгана жил би (энд) нутаглав.

Хоёрдугаар хувилбар:

1. Ичи өз Инэнчү би устгав.
2. (Тэгээд) хулгана жил би (энд) нутаглав гэжээ.

Тэрбээр Цэнхэрмандалын Бургаст цохионы бичээс нь ер гэмтэлгүйн дээр уг бичээсэнд ийм тийм хэмээн эргэлзээ төрүүлэх бүдэг балархай үсэг-зурлага нэг ч үгүй гээд хүүрнэн буй дурсгал бичгийн үсэг-зурлагын хэв болон зөв бичлэг нь Тайхир чулууны түрэг бичээстэй ихээхэн нийлж байгаагаас гадна Тайхир чулууны түрэг бичээсийг эрдэмтэд 7 дугаар зууны үед холбогдох болов уу гэж таамагласнаар эл бичээсийг мөнхүү үед тохиолдуулах саналтай байна. Тэгэхдээ “хулгана” жил хэмээн тодорхой заан өгүүлсэн тул YII зуунд тохиох 9 удаагийн хулгана жил нь 602, 614, 626, 638, 650, 662, 674, 686, 698 он билээ гэж бичээсийн түүхэн он цагийг тогтоохыг эрмэлзсэн байна.

С.Г.Кляшторный гуайн судалгаа

Бичээсийг “iči öz ününčü qirγum küsgü jylqa qontym” гэж галиглаад “Я, старший брат, Оз Инчю Кыргы[из рода с такой тамгой] имел [здесь] стоянку в год мыши” хэмээн орчуулжээ (Кляшторный, 1978: 151-159). Тэрбээр эл дурсгалын бичгийг уншсан судалгаагаа 2003, 2006 онд хэвлүүлсэн бүтээлдээ мөн оруулсан байна (Кляшторный, 2003; 2006).



Бичээс бүхий хадны ерөнхий байдал



Цэнхэрмандалын бичээс

Бидний судалгаа

Эл бичгийн дурсгалыг уншиж тайлсан эрдэмтдийн судалгаа, уншлага нэг мөр болоогүй учир бид тухайн газар хэдэнтээ очиж, нягтлан судалсан билээ.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

ՊՆԿՈՒ ԻՅԿԿԻՒՄԻԼԻ.1

✧T)7HJHJTDH€H9.2

Бичээсийн үсгийн галиг:

1. i č i ü z n nč ü Q R G m

2. küsgü Y i L Q a Q W N T m

Бичээсийн үгийн галиг:

1. i č i ö z inänčü qıryım

2. küsgü jılqa: qontim

Үгчилсэн орчуулга:

Ичи Өз Иненчү (миний) бичиг
Хулгана жилд хонов би

Утгачилсан орчуулга:

Ичи Өз Иненчү (миний) бичиг (буюу)
Хулгана жилд нутаглав би

Бичээсийн нэгдүгээр мөрд гарах “qīrγīm” хэмээх үгийн тухайд судлаачдын санал нэлээд зөрүүтэй байгаа бөгөөд бид уул үгийг “qīr-γ-m” хэмээн бүтцээр задлан үзэх саналтай байна. qīr- үйл язгуур нь “цоолох, цоолборлох, ухах, малтах” гэх мэт олон утгатай (Древнетюркский словарь, 1969). Ер эртний түрэгүүдэд холбогдох гэрэлт хөшөө, хад чулуунаа бичиг бичих, сийлэх тухайд хэрхэн үйлдсэн байдлаас шалтгаалан “biti- бич-, bediz-сийл-, ug- цохи-, toqi- тогши-” гэх мэт үг хэллэгийг сонгон хэрэглэсэн байдаг. Цэнхэрмандалын бичээс нь чулууг ямар нэгэн зүйлээр ухаж сийлсэн сийлмэл бичээс болох нь тодорхой бөгөөд энэ онцлогийг харгалзан “qīr-” язгуурыг утга шилжүүлэн хэрэглэсэн байх боломжтой юм. Уул язгуур үндсэнд нэр үг бүтээх “-γ” дагавар авч, нэгдүгээр биед хамаатуулах “-m” нөхцөлөөр хэлбэржсэн хэмээн үзэж “(миний) бичиг(сийлбэр)” гэж утгачлан орчууллаа.

Энэхүү 2 мөр бичээс утгын хувьд тус бүр биеэ даасан шинжтэй боловч 1-р мөрд үйлийн эзнийг, 2-р мөрд үйлийг тодорхойлсон байдалтай өвөрмөц найруулгаар бичигджээ. Өөрөөр хэлбэл “Ичи Өз Иненчү би хулгана жилд нутаглав” хэмээн нэгтгэн ойлгож болох юм.

НОМ ЗҮЙ

- Болд Л., 1990. Цэнхэр Мандалын түрэг бичээс, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, т. 139-142.
- Вяткина К.В., 1958. Кентейская руническая надпись, -Филология и история Монгольских народов, М., с. 217-218.
- Древнетюркский словарь, 1969. М.-Л.
- Кляшторный С.Г., 1978. Наскальные рунические надписи Монголии (Тэс, Гурвалжин –Ула, Хангыта- Хат, Хэнтэй). Тюркологический сборник 1975. М., с. 151-159.
- Кляшторный С.Г., 2003. Хэнтэйская надпись (Наскальные рунические надписи Монголии. Тэс, Гурвалжин–Ула, Хангыта- Хат, Хэнтэй). История Центральной Азии и памятники рунического письма, СПб, с. 75-77.
- Кляшторный С.Г., 2006. Хэнтэйская надпись (Наскальные рунические надписи Монголии. Тэс, Гурвалжин –Ула, Хангыта- Хат, Хэнтэй). Памятники древнетюркской письменности и этнокультурная история Центральной Азии. СПб., с. 125-127.
- Пэрлээ Х., 1968. Карта рунических писем на территории МНР. Studia Museologica. Tom.I, fasc.2, УБ, т. 12.
- Пэрлээ Х., 1974. Дорнод монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглэлээс). Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, УБ, т. 71-74.
- Фэн Цзя-шэн, 1959. Руническая надпись из Восточной Монголии. Советская этнография, №1, М., с.3-6.
- Шинэхүү М., 1977. Цэнхэрмандалын эртний түрэг бичээсийг дахин уншсан нь. Археологийн судлал, Tom.VII, fasc.8, УБ, т. 102.
- Rintchen B., 1968. Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, УБ (Oulanbator), pp. 43.

SUMMARY

Ts.Battulga, N. Gerelmaa

TSENKHERMANDAL INSCRIPTION

A monument with 2 lines of runic inscriptions was first found in May 1895 by D.A. Klements in Burgastain bichigt tsokhio, 15 km to the Northeast from Tsenkhermandal soum, Khentii province.

Origin of the inscription:

ᠶᠡᠢ ᠴᠡᠢ ᠤᠵᠤ ᠨᠢᠨᠴᠤ 1

ᠬᠦᠰᠭᠤ ᠶᠡᠯᠤᠰᠤ ᠵᠢᠯᠠᠭᠠ 2

Transliteration:1. i č i ū z n nč ü Q R G m

2. küsgü Y i L Q a Q W N T m

Transcription:

1. i č i öz inänčü qīryīm

2. küsgü jīlqa: qontīm

Translation:

1. Ichi Uz Inanchu's inscription of mine.

2. I settled here in the year of rat